



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 09-НИЙ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 12 дугаар сарын 09-ний өдөр Даваа гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-4
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	5-25

- 1.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./ 5-22
- 2.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/ 22-25

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
12 дугаар сарын 09-ний өдөр /Даваа гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 11 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилоттой: Б.Дэлгэрсайхан, Р.Эрдэнэбүрэн;

Чөлөөтэй: Н.Алтаншагай, Э.Бат-Амгалан, Б.Батбаатар, Э.Болормаа, Н.Наранбаатар, П.Наранбаяр, Н.Номтойбаяр, Ө.Шижир, Д.Цогтбаатар;

Эмнэлгийн чөлөөтэй: Д.Ганбат.

Нэг.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ./

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганхуяг, Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга С.Тулга, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Б.Амарбаясгалан, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга дарга И.Батхүү, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч З.Цэдэнжав, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Я.Самбууням, Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын аудитын менежер Ю.Энхтуяа, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга Я.Гантөмөр, мөн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Т.Мөнх-Эрдэнэ, Цөмийн энергийн комиссын Ажлын албаны Тамгын газрын дарга Б.Баатарцогт нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх О.Одончимэг, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт,

шинжилгээний хэлтсийн дарга Я.Эрдэнэсамбуу, референт Ц.Лхагвагэрэл нар байлцав.

Төслийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Б.Жавхлан, төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч З.Цэдэнжав нар танилцуулав.

Танилцуулга болон аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаяр, Л.Энхнасан, Н.Батсүмбэрэл, С.Эрдэнэболд нарын тавьсан асуултад Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт, Сангийн сайд Б.Жавхлан, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, Н.Батсүмбэрэл нар үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.12.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх О.Одончимэг, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Я.Эрдэнэсамбуу, референт Ц.Лхагвагэрэл нар байлцав.

Төслийн талаарх танилцуулгыг Батлан хамгаалахын сайд С.Бямбацогт танилцуулав.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн:

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Хосбаярын тавьсан асуултад Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн хариулж, тайлбар хийв.

Төслийн 3, 4 дүгээр зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 08 минут үргэлжилж, 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр 12 цаг 19 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ
ЧУУЛГАНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ 12 ДУГААР САРЫН 09-НИЙ ӨДӨР /ДАВАА ГАРАГ/-ИЙН
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүддээ энэ өглөөний мэндийг хүргэе ээ.

Та бүхэндээ Байнгын хорооны ирцийг танилцуулъя. Байнгын хорооны гишүүдийн маань ирц бүрдсэн байна. Нийт гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн байна.

Очирбатын Амгаланбаатар гишүүн, Чинбаатарын Анар гишүүн, Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн, Хажикберын Жангабыл гишүүн, Батбаярын Жаргалан гишүүн, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн, Ганбатын Хосбаяр гишүүн, Баттөмөрийн Энхбаяр гишүүн, Жадамбын Энхбаяр гишүүн, Лутаагийн Энхнасан гишүүн, Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн, Сүхбаатарын Эрдэнэболд нарын гишүүд хүрэлцэн ирснээр өнөөдрийн Байнгын хорооны хуралдааны ирц бүрдсэн байна аа.

Ингээд 2024 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал. 2 асуудал байгаа.

Нэгдүгээр асуудал. Монгол Улсын 2025 онд Төсвийн тухай, нийгмийн даатгалын сангийн 2025 онд төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд.

Хоёрдугаарх нь Монгол Улсын 2025 онд төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 онд Төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улс Улсын Их Хурлын тогтоолын төслүүд гэсэн ийм 2 асуудал байгаа.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулаад саналтай гишүүд байна уу? Алга байна. Ингээд хэлэлцэх асуудалдаа орцгооё.

Нэгдүгээр асуудал. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг хийж эхэлье ээ.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Сангийн сайд Болдын Жавхлан, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Жигжидийн Ганбат, Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газрын дарга Минжиддоржийн Санжаадорж, Сангийн яамны Санхүү, төсвийн бодлогын судалгааны газрын дарга Ганболдын Золбоо, Сангийн яамны Татварын бодлогын дарга Бямбарагчаагийн Тэлмүүн, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө

оруулалтын газрын дарга Жамъяншаравын Дэлгэржаргал, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга Зоригтбаатарын Энхболд, Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга Пүрэвдоржийн Бат-Эрдэнэ, Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Энхтөрийн Батмөнх, Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга Лувсанвандангийн Ичинноров, Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга Солонгын Тулга, Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Лувсандоржийн Гантогтох, Сангийн яамны хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Булганхүүгийн Ганзориг, Сангийн яамны Санхүүгийн зах зээл, даатгалын хэлтсийн дарга Батбаатарын Амарбаясгалан, Үндэсний аудитын газрын орлогч дарга Цэдэнжав, Санхүү Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Цэвэгсүрэнгийн Наранчимэг, Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитын менежер Юрагийн Энхтуяа, ГХЯ-аас Гадаад харилцааны сайд Батцэцэг сайд, Лханаажавын Мөнхтүшиг ГХЯ-ны ТНБД, Чүлтэмийн Ганбат ГХЯ-ны Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга, БХЯ-аас Батлан хамгаалахын сайд Сандагийн Бямбацогт, БХЯ-ны ТНБД Дагвадоржийн Ганхуяг, Зэвсэгт хүчин жанжин штабаас Зэвсэгт хүчин Жанжин штабын санхүүгийн хэлтсийн дарга хурандаа Балжиннямын Бүрэнтөгс, ОБЕГ-аас ОБЕГ-ын дэд дарга хурандаа Ядмаагийн Гантөмөр, мөн газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга хошууч Төрмандахын Мөнх-Эрдэнэ, Цөмийн энергийн комиссоос тус комиссын ажлын албаны Тамгын газрын дарга Балдоржийн Баатарцогт гэсэн бүрэлдэхүүнтэй оролцож байна аа.

Ингээд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн талаарх танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан сайд танилцуулна аа.

Жавхлан сайдын микрофоныг өгье 3 Номер 3 номер.

Б.Жавхлан: Баярлалаа. Эрхэм байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурал Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хууль тогтоомжийн төслийг 2024 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр хэлэлцэн баталсан. Үүнээс хойш Монгол Улсын хэрэглэгчээс гадаад зах зээлийн тогтворгүй байдал, түүхий эдийн үнийн хэлбэлзлээс үүдэн 2025 оны төсвийг үр ашигтай, хэмнэлттэй, алдагдалгүй батлах шаардлагатай гэсэн үндэслэлээр 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр бүхэлд нь хориг тавьсан.

Улмаар Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэн хүлээн авч алдагдалгүй төсөв батлах батлах чиглэл өгсний дагуу Засгийн газраас батлах чиглэл өгсний дагуу Засгийн газраас Монгол Улсын 2024 оны төсвийн төслийг дахин боловсруулж танилцуулж байна аа.

Ингээд төсвийн төсөлд зардлыг бууруулахад дараах зарчмыг баримталлаа. Нэгд, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, ЭМД-ын сангаас санхүүжүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг нийгмийн халамжийн сангаас олгох хүүхдийн мөнгөн тэтгэмж, халамжийн тэтгэвэр, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, асаргааны тэтгэмж, түүнчлэн төрийн албан хаагчийн цалин хөлс болон тэтгэвэрт гарахад нэг удаа олгох тэтгэмж хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж, зээлийн үйлчилгээний төлбөр мөн хуульд заасны дагуу Улсын Их Хурлын ХЗБХ-оос төсвийг нь хянан жилийн төсөвт тусгуулахаар ирүүлсэн

шүүхийн байгууллагууд болон ХЭҮК зэрэг байгууллагуудын урсгал зардлыг тус тус өргөн барьсан байгаа.

Хоёрт төсөвт байгууллагын үйл ажиллагааны зарим зардлыг дараах байдлаар 10-аас 100 хувь буурууллаа. Үүнд нэг салбараа харгалзахгүйгээр бүх төсөвт байгууллагын тавилга, эд хогшил худалдан авах, сургалт, семинар, хурал зөвлөгөөн хийх биеийн тамирын уралдаан тэмцээн зохион байгуулах гэрээт ажилтан ажиллуулах, дуудлагын авто машин хөлслөх, зөвлөл, хороо, комиссын гишүүний урамшууллын зардлыг 100 хувь буурууллаа. Соёлын эрхийн бичиг, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих Кино урлагийг дэмжих сан, Засаг захиргааны нэгж, төрийн захиргааны байгууллагыг үр дүнгээр шагнах, урамшуулах, идэвхтэй амьдралын хэвшлийг дэмжих болон эрүүл идэвхтэй амьдрал Хөтөлбөрийн зардлыг 100 хувь бууруулах.

3.Эрүүл мэнд болон тусгай чиг үүргийн байгууллагаас бусад бүх байгууллагын тээвэр шатахууны зардал төрийн өндөр дээд айлчлал болон гаднын өндөр түвшний зочин төлөөлөгч хүлээн авахаас бусад гадаад албан томилолт болон зочин төлөөлөгч хүлээн авах зардал, Эрүүл мэнд, боловсрол, батлан хамгаалах, гадаад харилцаа, хууль зүй, дотоод хэргийн салбараас бусад салбарын дадлага, бэлтгэл, сургуулилт хийх зардал, бүх шатны төсвийн байгууллагын дотоод албан томилолт, бичиг хэргийн зардал, багаж, техник хэрэгсэл худалдан авах зардлыг тус тус 50 хувиар бууруулах, улсын төсвийн хөрөнгөөр шинээр гүйцэтгэх геологийн хайгуул судалгааны ажлыг 50 хувь бууруулах,

5.Дээр дурдсан 5-аас 100 хувь бууруулах зардлуудаас гадна байр ашиглалтын зардал, хангамж, бараа материал, нормативт, эм бэлдмэл, нормын хувцас, хоол, урсгал засвар, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас, шилжүүлэг, эргэж төлөгдөх зээл, бараа, үйлчилгээний бусад зардал, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх арга хэмжээ, боловсролын тэтгэлэг, авто зам, гүүрэн байгууламжийн засвар, ашиглалтын зардлыг 10 хувиар тус тус буурууллаа.

3.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан төсөл арга хэмжээнээс гэрээ байгуулсан ажлыг эхлүүлсэн төслүүдийг дуусгана. 4 гэрээ байгуулаагүй ажил эхлээгүй улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг хойшлуулна.

5.Зарим эх үүсвэр, ТЭЗҮ, зураг төсөв, тоног төхөөрөмжийн санхүүжилтийг бууруулж хэлэлцээрийн шатад байгаа төслийг хойшлууллаа.

6.Гадаад зээл, зээлийн ашиглалтыг тодорхой хэмжээнд бууруулж хэлэлцээрийн шатад байгаа үндэсний хиймэл дагуулын төсөл болон бусад төслийн зээлийн ашиглалтыг хойшлууллаа.

7.Хавдар судлалын үндэсний 2 хөрөнгө оруулалтыг нэмж тусгалаа.

Нэгдсэн төсвийн нийт орлогыг төсвийн хөрөнгө оруулалт зардлын бууралттай холбогдуулан 394.8 тэрбум төгрөгөөр буурахаар тооцлоо. Ингэснээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого тусламжийн дүн 33.5 их наяд төгрөг буюу ДНБ-ий 35 хувь нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 33.5 их наяд төгрөг буюу ДНБ-ий 35 хувьд

хүрч нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл алдагдалгүй боллоо. Суурь тэнцэл ДНБ-ий 3.3 хувийн нэмэх байхаар тооцлоо.

Эрхэм Байнгын хорооны дарга, гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн 11 хуулийн төсөл, 4 Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Эдгээр тогтоолын төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Жавхлан сайдад баярлалаа.

Ингээд хуулийн төслүүдийн талаар Үндэсний аудитын газраас хийсэн аудитын дүгнэлтийн талаарх танилцуулгыг Аудитын үндэсний газрын орлогч дарга Цэдэнжав дарга танилцуулна аа. 2 номерын микрофоныг өгье.

3.Цэдэнжав: Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллага төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.7, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 12 дугаар сарын 4-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг гүйцэтгэн аудитын тайлан дүгнэлтийг Улсын Их Хурал, Засгийн газарт хүргүүлсэн болно.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс гадаад зах зээлийн тогтворгүй байдал түүхий эдийн үнийн хэлбэлзлээс үүдэн 2025 оны төсвийг үр ашигтай хэмнэлттэй алдагдалгүй батлах шаардлагатай гэсэн үндэслэлээр 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр бүхэлд нь хориг тавьсан нь ач холбогдолтой болсон байна аа.

Иймд: Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар Ерөнхийлөгчийн хоригийг 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр хэлэлцэн хүлээж авч алдагдалгүй төсөв батлах чиглэл өгсний дагуу Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг шинэчлэн боловсруулж дахин өргөн барьсан байна. Тус аудитын зорилго нь Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөл, нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангасан эсэх төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх зорилтод нийцсэн эсэхэд хянаж дүгнэхэд чиглэсэн болно оо.

Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөлд тус Байнгын хороонд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийг дараах байдалтай төсөвлөжээ.

Үүнд:

Төсөвт төвлөрүүлэх орлогыг Гадаад харилцааны сайд 16.1 тэрбум төгрөг, Батлан хамгаалахын сайд 43.2 тэрбум, нийт 59.3 тэрбум төгрөгөөр, төсвийн зардлыг 2025 оны ҮАБЗ-д 22.6 тэрбум төгрөг, Гадаад харилцааны сайд 262.3 тэрбум төгрөг, Батлан хамгаалахын сайд 821.6 тэрбум төгрөг, нийт 1 их наяд 106.5 тэрбум төгрөг буюу 2025 оны суурь төсвөөс ҮАБЗ-ийн даргад 0.3 тэрбум төгрөг нэмэгдэж Гадаад харилцааны сайдын сайдын төсвөөс 13.6 тэрбум төгрөг, Батлан хамгаалахын сайдын төсвөөс 11.8 тэрбум төгрөгийн, нийт 25.1 тэрбум төгрөгийн зардал тус тус хасагдсан байна аа.

Монгол Улсын 2025 оны төсвийн төсөл урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын үзэл баримтлал улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн боловч дараах асуудлыг цаашид анхаарах нь зүйтэй байна.

Үүнд:

Нэгдүгээрт гадаад хүчин зүйлийн нөлөөлөл уулын уурхайн салбарын голлох нэрийн бүтээгдэхүүний эрэлтээс шалтгаалж нүүрсний экспорт төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй тохиолдолд зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэр дутагдах, орлого тасрах эрсдэлийг тооцох шаардлагатай.

2. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөвт өөрчлөлт оруулах бүрд нэмж өөрчилж байгаа нь төсвийн удирдлагын зарчим, сахилга батыг алдагдуулж дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн ач холбогдлыг бууруулж байна.

3. Цахим систем болон ТЭЗҮ боловсруулах ажлын өртөг зардлыг тооцож төлөвлөх, хянах, хэрэгжүүлэх, хүлээн авахтай холбоотой зохицуулалт, жишиг үнэ, заавар журам хангалтгүй байгаа нь төсвийн өртгийг үндэслэлтэй тооцож үр ашигтай төлөвлөхөд сөргөөр нөлөөлж байна.

4. Төсвийн орлогын урсгал зардлыг хумьж зарим зардлыг хэрэгжиж эхлээгүй хөтөлбөр үйл ажиллагааг зогсоохоор төлөвлөсөн нь төсвийн зарлагын ДНБ-д эзлэх харьцааг бууруулсан сайн талтай боловч зардлыг хэт механикаар хассан нь 2025 онд төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг бууруулах тоо, хэмжээг хумих эрсдэл үүсэх магадлалтай байна.

5. Төрийн үйлчилгээг илүү цомхон бүтэц, ухаалаг байдлаар үзүүлэхийн тулд төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх тогтолцооны өөрчлөлтийг хууль эрх зүйн орчинд бүрдүүлэх шаардлагатай байна.

6. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүүлгийн 12-т төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аудитын хуулийн этгээдээр аудит хийлгэж болно. Тухайн санхүүгийн жилд аудит хийлгэх төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт болон аудит хийх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах этгээдийг Засгийн газар тогтооно гэж тусгасан нь Улсын Их Хурлын Засгийн газарт тавих хяналтын зарчмыг алдагдуулахаас гадна Монгол Улсын Үндсэн хууль түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжтой нийцэхгүй байна аа.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Цэдэнжав даргад баярлалаа. Ингээд хууль санаачлагчаас болоод төсвийн ерөнхийлөн захирагчдаас асуулт асуух гишүүд байна уу? Нэрсийг авъя. Батсүмбэрэл гишүүнээр тасаллаа. Хосбаяр гишүүн асуулт асууна.

Г.Хосбаяр: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Саяхан Боловсролын сайдаар ахлуулсан Улсын Их Хурлын 8 гишүүн Япон улсад очиж ажилласан. Япон улсад байгаа Монголын Элчин сайд, ЭСЯ-ыхан бас ЭСЯ-ан дээрээ хүлээж авч одоо яг тэнд ажиллаж байгаа ЭСЯ-ны барилга байшинтай холбоотой асуудлыг бид нарт санал тавьсан. ЭСЯ бол 1972 оны гэсэн байх байшинтай юм байна лээ. Тэгээд одоо бол барилга нь нэлээн тийм муудчихсан хулгана, харах гүйдэг ажиллаж амьдрахад тийм нэлээн таагүй орчин бүрдсэн тухай ярьж байна лээ. Мөн одоо Монголын аудитын байгууллагынхан саяхан очиж ажилласан гэсэн. Удахгүй бас энэ Барилгын хөгжлийн төв мэргэжлийн тэр барилга байшингийн чанар аюулгүй байдлыг шалгах хүмүүсийг явуулна гэж ингэж ярьсан юм байна лээ. Тэгэхээр тэр Япон улсад байгаа ЭСЯ-ны барилга бол одоо нэлээн тийм хуучирч муудсан тэр газар хөдлөлт аюулгүй байдлын хувьд бол стандарт шаардлага норм дүрэм хангахгүй болсон ийм асуудлыг ярьсан. Тэгээд энэ оруулж ирсэн төсөв дээр харж байхад гадаад харилцааны сайдын багц дээр засвар гээд л нэг 8.5 тэрбум төгрөг байгаагаас биш өөр ямар нэгэн тийм хөрөнгө оруулалт тэр гадаад улсад байгаа ЭСЯ-дын барилга байшинтай холбоотой зардал алга аа.

Тэгэхээр бид нарын чухал хөршид байгаа энэ тогтмол үйл ажиллагаа явуулдаг маш олон хүн үйлчлүүлдэг маш олон хүн орж гардаг. Энэ ЭСЯ-дын байр байшин шинээр барих асуудлыг ер нь бодож төлөвлөсөн юм байгаа юу? Бидэнд өгсөн мэдээллээр бол 1 мянган м² газартай юм байна лээ. Түүн дээрээ шинээр байшин барихад 2, 3 компаниас санал авсан 20 орчим сая долларын төсөвт өртгөөр ингээд шинэ ЭСЯ-ны 3 давхар байшин бариад өгч болно гэсэн ийм саналууд ирсэн гээд байгаа. Тэгэхээр энэ асуудлыг бас яг Элчин сайд албан ёсоор уламжилж өгөөрэй бас энэ бид нар олон түвшиндээ ярьж байгаа гээд ингэсэн.

Тэгэхээр энэ асуудал дээр ер нь яаж анхаарч байгаа юм бэ? Цаашдаа ер нь энэ гадаад улсад байгаа ЭСЯ-дуудын барилгын засвар тэр шинээр барьсан худалдан авах мөн шинээр барих энэ асуудал дээр ер нь ямар бодлого барих юм бэ? Эсвэл тэр тухайн улсаасаа хөрөнгө оруулалт татаад тэндхийн хувийн хэвшилтэй ч юм уу хамтраад ингээд явах юм уу энэ талаар тодорхой төлөвлөсөн зүйл байгаа юу гэж асуумаар байна аа? Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Хосбаяр гишүүний асуултад хариулья. Батцэцэг сайд.

Б.Батцэцэг: Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өглөөний мэнд хүргэе ээ. Хосбаяр гишүүний хөндөж байгаа асуудал маш чухал байгаа. Манайх одоо сүүлийн 2016 оноос хойш л бас нэг хэмнэлтийн горимоор яваад байгаа. Тэрнээс бол гадаадад байгаа ЭСЯ-дуудын байраа өөд нь татах, зарим газар үл хөдлөх хөрөнгө худалдаж авах ийм зайлшгүй шаардлага байгаа. Тэгээд Япон улсад байгаа ЭСЯ-ны хувьд бол үнэхээр газар хөдлөлтөд тэсэхгүй гэдэг ийм дүгнэлтийг айлын талаас өгч энэ байшингаа зас гэдэг шал шаардлагыг тавьдаг. Тэгээд өртөг нь их өндөр байдаг учраас одоо бол нэг жижиг сажиг засвар хийгээд бол нэмэргүй нэг бол буулгаж шинээр барих, нэг бол тэр байрлал маш ашигтай бүсэд зэрэглэлийн бүсэд байдаг учраас тэр газрыг зараад шинэ газар байшин худалдаж авах ийм 2 сонголт л байгаад байгаа юм.

Тэгээд энэ жилийн төсвийн хувьд бид нар 20 сая доллар доод тал нь 15 сая долларын ийм зардал гарахаар тооцоо хийсэн учраас Японд ЭСЯ-ны барилгыг засах төсвийг харамсалтай нь тавиулж чадаагүй. Тэгээд энэ дээр бас боломж бололцоо муу байгаа гэж ойлгож байгаа. Бусад газар бид нар яах вэ ЭСЯ-дуудад ингээд засвар хуваарьтай хийдэг. Тэгээд энэ жил бид нар бас нэг 12 тэрбум төгрөг уг нь бол үл хөдлөх хөрөнгө дээр тавьсан байсан. Тэгээд тэр маань харамсалтай нь хасагдсан байгаа.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Энхнасан гишүүн асуулт асууя.

Л.Энхнасан: Сайн байцгаана уу? Өглөөний мэнд хүргэе. 2, 3 асуух юм байна. Энэ гадаадад суугаа дипломат төлөөлөгчийн газруудын орон тоог энэ 40-өөр нэмэхээр энэ Засгийн газар шийдсэн байсан. Энэ төсөвт орсон уу, нэмэгдсэн үү? Ерөнхийдөө ингээд харахлаар нэмэгдсэн харагдаж байна. Тэгэхдээ яг тусгагдсан эсэхээ мэдэхгүй байна аа. Тэгээд энэ нөгөө байр ашиглалттай холбоотой энэ нэг тогтмол зардлууд жишээлбэл Буэнос Арес, Мадрид гээд ингээд нэмэгдсэн байх юм. Энэ дээр Аргентинд элчин сайд нэмж байснаас уг нь Бразилд нөгөө ЭСЯ-аа сэргээгээд Мадридад шинээр нээгээд Энэ Эденбург биш Дублийн Франкфуртад нөгөө дипломат төлөөлөгчийн газраа нээх нь зүйтэй биш байсан юм уу? Энэ эс үгүй бол миний авсан мэдээлэл буруу байна уу? Энэ эс үгүй бол энэ дээр буруу бичигдсэн байна уу? Тэгээд миний мэдэхээр ер нь Гадаад хэргийн яам бол нөгөө 1996 оноос л 130-аас 157 хүний орон тоотой л дандаа ажилладаг юм. Энэ гадаад харилцааны бодлого ингээд дипломат үйл ажиллагаа өргөжсөн энэ үед сайдаас ер нь асуумаар байна. Энэ дотоодынхоо энэ бүтэц нь ер нь хангалттай хүртээмжтэй байдаг уу? Хангалттай байдаг уу? Та бүхэн энийгээ ер нь цаашдаа нэмэхээр ийм бодлого байна уу? гэсэн ийм асуулт байна аа.

Г.Тэмүүлэн: Энхнасан гишүүний асуултад хариулъя. Батцэцэг сайд.

Б.Батцэцэг: Баярлалаа Энхнасан гишүүндээ. Тийм тэр Ганбат дарга тэр буруу мэдээлэл оччихсон байна. Бид нар Бразилд ЭСЯ-аа сэргээж нээх гэж байгаа шүү. Хуучин бид нар нэлээн ажил болж байж ЭСЯ байгуулсан. Тэгээд ЭСЯ-ыг бас одоо төсөв хэмнэж байна гээд түр царцаачихсан хаачихсан. Энэ нь өөрөө айлын талтай харилцаа талдаа ч гэсэн бас ийм онцгүй үйлдэл болсон. Тэгээд бид нар Индонезыг энэ жил буцаагаад нээсэн. Энэ жилийн төсөвт Индонезын ЭСЯ-ыг төсвийг нь тавьчихсан байсан учраас ингээд нээгдээд хэвийн ажиллаж байгаа. Ирэх жил Бразилд бид нар ЭСЯ-аа буцаагаад сэргээж нээнэ. Бид нар Дублинд, консулын газар, Франкфуртад консулын газар байгуулахаар байгаа шүү. Тэгээд бид нарын сүүлийн төсөл нь наадах чинь биш байх шиг байна. ГХЯ-ны төвийн орон тоо бараг хуучин үеийнхээрээ байгаа. Ер нь зохистой харьцаа бол гадаадад байгаа ажиллаж байгаа дипломатууд дотоодод ажиллаж байгаа дипломатууд бараг тэнцүү харьцаатай байдаг энэ олон улсын жишиг байдаг.

Манайх бол 2 дахин бага байдаг. Манай дипломатуудын цалин бол дэлхийн дунджаас 40 хувиар бага байдаг. Тэгэхээр бид нар энэ гадаад харилцаа тэлж байна. Ер нь бол хүний нөөцийн бодлого дээрээ төлөвлөлтүүдээ нэлээн хийсэн. Тэгээд энэ жилийн хувьд бол бид нар 40 орон тоо бол нэмэхээр ингээд нэмээд оруулсан Засгийн газрын хуралдаанаар бид нар шийдвэрлэсэн. Ирэх жил бид нар Коп 17 гээд цөлжилтийн НҮБ-ын их том хурлыг зохион байгуулна. Ер нь бол манай яамны ажилтнууд энэ дотооддоо болж байгаа олон улсын арга хэмжээ олон айлчлалуудыг

бол зохион байгуулахад бол маш их хүн хүний нөөцийн дутагдалтай болж байгаа. Ховор хэлтэй хүмүүс бас багасаж байгаа.

Тэгэхээр цаашдаа ингээд шатлалтай нэмье гэж бодож байгаа. Тэр хүрээндээ энэ жил тодорхой тооны орон тоо нэмэгдэж байгаа.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Батсүмбэрэл гишүүн асуулт асууя.

Н.Батсүмбэрэл: Энэ сая танилцуулга дотор Цөмийн энергийн комисс танилцуулагдсан. Бид нарт Байнгын хорооны даргын танилцуулга дотор шүү дээ. Бид нарт өгсөн материал дотор Цөмийн энергийн комиссын зардал алга байна. Энэ хааччихав эс үгүй бол байхгүй бүтцийг Байнгын хорооны дарга зарлав уу? Бид нар тэр материал тараасан материалд энийг хасчхав уу? 1 дүгээрт.

Хоёрдугаарт, харьяа сайд нар байж байна. Батлан хамгаалахын сайд, Гадаад харилцааны сайд. Төсөв дээр салбарын төсвүүд хэр орсон бэ? Энэ дээр сайд нар өөрсдийнхөө байр суурийг хэлээч. Бид БХЯ дээр очиж танилцсан шүү дээ Байнгын хороогоороо. Тэгээд нэлээн хүндрэл бэрхшээлтэй асуудлуудыг ярьсан. Түүнийг шийдэх тал дээр бодлогоо эхлүүлээд хийж чадахаар хэмжээний төсвийн эхлэл тавигдав уу, ер нь ямар байдлаар та төслийнхөө менежментийг хийж байна вэ? ГХЯ дээр Батцэцэг сайдын яриад байгаа бодитой юм байна лээ. Тэр Монгол Улсын Ерөнхийлөгчийг дагалдаад 9 сард НҮБ-ын Ерөнхий ассамблейн хуралд оролцоод явсан. Монгол Улсын гадаад тэр тусгай дипломат байгууллагад ажиллаж байгаа хүмүүсийн цалин яалт ч үгүй бага байдаг юм байна. Тэдгээрийн ажиллах нөхцөл маш дутмаг байдаг юм байна. Үүнийг анхаарах ёстой юм байна. Ер нь гадаад харилцааны асуудал дээр бид нар мөнгө боллоцоогоор нь дэмжиж өгөх ёстой юм байна. Ингэж байж бид нар гадаад харилцаа, гадаад бодлого хүчтэй явна. Олон улсын үйл ажиллагаа идэвхтэй явж байгаа энэ цаг үед энийг маш бодитойгоор үр ашигтай талаас нь тооцож төсвийг нь хасах биш бодитой талаас нь хандах ёстой гэдгийг бас бодож үзээсэй гэж бодож байна.

Энэ дээр салбарын сайд ямар байр суурьтай байгаа вэ?

Гуравдугаар асуулт аудитаас асууя. Үндсэн 2025 оны төсөв нэг орж ирээд буцсан хориг тавигдаад. Одоо дахин боловсруулчихсан орж ирж байна. Энэ 2 төсөвт ямар ялгаа байна? Энийг нэг тодорхой хариулаадхаач.

Эдийн засгийн хөгжлийн яам энэ үргүй зардал давхардсан бүтэц дээр та нар дүгнэлт хийж байна уу? Ер нь энэ дээр та нар ажиллаж байгаа юу? Тэгээд ямар юмны билээ? Нэг яам байгуулчихсан хяналтын ч билүү дээ, яваад байдаг. Тэгээд тэр байдлаар яваад байна уу? Юу болоод байна? Энэ дээр та нар ажил хийдэг юм уу? Тэгээд 5 дахь асуултыг нь Сангийн сайдаас асууя. Энэ баахан ТУЗ-ууд байгаад байдаг. Эд нар дээр та нар ямар дүгнэлт хийж байна? Хэрэг эрхлэх газрын сайд нь овоо дуугараад эхэлнэ лээ. Үр ашигтай болгоё гээд. Нэг хүн олон ТУЗ-д ордог ийм тохиолдол байгаад байгаа. Хараад байхад яамны дарга нар ялангуяа энд тэндхийн төрийн нарийн газрын дарга нар энэ олон хүн давхардаад бүгд цалин авч байгаа юу. Үүний тооцоолол гарсан уу? Энэ ямар үр ашигтай юм бэ? Энэ дээр юм байна уу гэдгийг асуулт авч байгаад тодруулъя.

Г.Тэмүүлэн: Сангийн сайд түрүүлээд хариулаад явж байх уу? Тэгье 3 номер.

Б.Жавхлан: Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя. Гадаад харилцааны хувьд бол бид цаашдаа улам их идэвхжих, тэлэх бүүр онцын шаардлагатай ийм цаг мөчид бид байгаа.

Тийм ч учраас дахин баригдсан төсөв дээр Улсын Их Хурлын гишүүд маань энэ гадаад харилцааны зардал дээр бас нэлээн цаашдаа ядаж байгааг нь дэмжиж өгөөсэй гэж хүсэж байна. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны гишүүд энэ тал дээр дуугарч байгаад би баяртай байна. Ингээд шинээр боловсруулж орж ирэхдээ төрийн 3 өндөрлөгийн гадаад айлчлал болон өндөр дээд түвшний гаднаас ирэх айлчлалыг хүлээж авах энэ зардлууд дээр бид нар нийт хөрөнгө бууруулаагүй. Харин төсвийн ерөнхийлөн захирагч нарт яамдуудын гадаад томилолтыг 50 хувь бууруулсан байгаа. Энэ яалт ч байхгүй л бид алдагдалгүй төсөв тэнцлээ барихын тулд ингэсэн. Төрийн дээд хэмжээний айлчлалыг хийсний дараа энэ мөрөөр дунд, доод, шатын техникийн түвшинд одоо гадаад харилцаа үргэлжлэх нь. энэ ч юуны хувьд хамгийн дараалалтай, энэ чинь логиктой зүйл байдаг учраас энэ дээр бас Байнгын хорооны гишүүд маань дэмжээд оруулж ирсэн төсвөө ингээд цааш нь аваад явахыг дэмжиж өгөөч гэж хүсье ээ. Тэр барилга байгууламжуудын хувьд бол гол гол том улсуудад дээр байгаа яамдуудынхаа барилга байшин дээр бас онцгой анхаарч эхлэх шаардлагатай болж ирж байгаа. Түрүүн Японыхыг Батцэцэг сайд бараг товчхон хэлчихлээ дээ. Ер нь яах вэ нэг хувилбар байгаа нь одоо байгаа байшингаа нэг газартаа нь зарж борлуулбал бас нэг хэсгийг нь бас төлчих боломжтой юм байна лээ. Нэлээн тийм үнэ өндөр үнэтэй боломжийн дүүрэгт үнэ хүрчихээр дүүрэгт байдаг гэсэн ийм мэдээлэл өгсөн тиймээ?

Хамгийн сүүлд бүүр тэр хувилбар дээрээ ажиллаж байгаа юм байна. Тэгээд саналаа ирүүлэх юм байна гэж ойлгосон. Энэ дээр тусгай төсөв хөрөнгө хэрэггүй ТӨБЗГ шийдвэрээ гаргаад Засгийн газартаа шийдээд борлуулчих юм бол ирэх жил шинэ байр авах бас боломжууд тодорхой хэмжээнд нээгдэх юм байна гэж ингэж харсан.

Тэр ТУЗ-д яамдуудын төлөөллүүд ордгийг бид хязгаарлаж байгаа. Энэ удаа тэр нөгөө хороодуудад байдаг болон өөр бусад ингэж давхар алба хашдаг тэндээсээ цалин авдаг зардлуудыг бүгдэнг нь хасаж оруулсан байгаа шүү Батсүмбэрэл гишүүн ээ. Тэрийг бас цөмийн энергийн комиссын зардлыг аль мэдэж байна уу энийг хариулаадхаач. Бат-Эрдэнэ дарга хариул. Бат-Эрдэнэ манай Төсвийн бодлогын газрын Зардлын хэлтсийн дарга Бат-Эрдэнэ.

Г.Тэмүүлэн: Тэлье. 5 номер дээр очоод хариулчих уу? Бат-Эрдэнэ дарга. Тэр хооронд аудитын дарга Цэдэнжав дарга. Наранчимэг дарга асуултад хариулчихъя. Аудит.

Ц.Наранчимэг: Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Наранчимэг байна. Монгол Улсын Засгийн газраас 2025 оны төсвийг 2 удаа өргөн барьсан. Эхний төсвөөс энэ өргөн барьсан төсөвт дараах өөрчлөлтүүд орсон байна гэж аудитаар дүгнэсэн. Засгийн газар урсгал зардлыг 2025 оны төсвөөс 2.3 их наядаар бууруулж анх удаа алдагдалгүй төсөв өргөн барьсан нь бас ахиц болсон байна гэж ингэж үзсэн байгаа. Мөн 2025 оны төсөв өмнө өргөн барьсан төсөв, энэ төсөв 2 хоёулаа урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай нийцсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагуудыг хоёулаа хангасан байгаа.

Нэг голлох авч үзсэн энэ төсөвт Засгийн газрын 2024 оны 8 сарын 30-нд Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025

Г.Тэмүүлэн: Нэмж хариулах уу? 1 номер.

Ц.Наранчимэг: Төсвийн тухай хуульд тусгасан 3.2 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 898 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй, 50 төсөл арга хэмжээг саяын 12 сарын 4-нд дахин өргөн мэдүүлсэн төсвөөс хассан. Ийм онцлогтой, ялгаатай төсвийг өргөн барьсан байна аа. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: 5 номер. Цөмийн энергийн комиссын төсвийн талаар Бат-Эрдэнэ.

П.Бат-Эрдэнэ: Төсвийн зарлагын хэлтсийн дарга Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Цөмийн энергийн комиссын төсвийг бол 11 сарын 8-нд батлагдсан төсвөөр 4.7 тэрбум төгрөгөөр өргөн мэдүүлээд батлуулсан байсан. Тэгээд сая алдагдалгүй төсөв өргөн барих энэ бодлогын хүрээнд бол 411.9 сая төгрөгөөр бууруулаад 4 тэрбум 343.3 сая төгрөгөөр дахиж өргөн барьсан байгаа. Энд бол голлох бууралт нь багаж техник хэрэгслийн зардалд 50 хувь буурсан. Энэ дээр 61.9 сая төгрөг. Мөн ингээд буурсан бол бусад зардлуудын хувьд бол нөгөө 10 хувь буурах энэ бууралтад ороод. Үлдсэн зардал нь буурсан байна. Цалин хөлсний хувьд бол ямар нэг бууралт байхгүй. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдад хамаарч байгаа.

Г.Тэмүүлэн: 5 номер.

П.Бат-Эрдэнэ: Байнгын хороодын гишүүдэд тараасан материалыг Сангийн яам бэлдээгүй. Төсвийн байнгын хороо, Төсвийн шинжилгээний алба бэлдсэн байгаа байх. Тэгэхээр яагаад Цөмийн энергийн комисс орсон талаар бидэнд мэдээлэл байхгүй байна би мэдэхгүй байна.

Г.Тэмүүлэн: Эдийн засгийн хөгжлийн яам байгаа юу? 4 номер.

И.Батхүү: Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя. Эдийн засаг хөгжлийн яамны ТНБД Батхүү. Улсын төсөв нь Төсвийн тухай хуулиараа жилийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байна. Жилийн хөгжлийн төлөвлөгөөнд үндэслэсэн байна гэсэн хуулийн заалттай байгаа. Эдийн засаг хөгжлийн яамны хувьд хуулиар заасан чиг үүргийн хүрээнд жилийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулахдаа бодлогын тэргүүлэх чиглэл дотроо таны дурдсан сая дурдсан асуудлуудыг зааж өгсөн байгаа. Тухайлбал хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого гээд бодлогын 4 дэх тэргүүлэх чиглэлийн хүрээнд төрийн төрийн албаны реформыг хэрэгжүүлж чадварлаг ухаалаг төрийн албаны тогтолцоог төлөвшүүлэх замаар төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, төрийн үйлчилгээний цахимжилт, процессын дахин инженерчлэлийг үргэлжлүүлэх, шийдвэр гаргалт, үйл ажиллагаанд иргэдийн хяналт тавих тогтолцоог хиймэл оюун ухаан, дэвшилтэт технологи ашиглан бүрдүүлж иргэдэд ойр төрийн үйлчилгээ бий болгоно оо гэж заасан байгаа.

Мөн Засгийн газрын үйл ажиллагаа төрийн албаны гүйцэтгэлийн удирдлага, төлөвлөлт, төсөл, тайлагналт, мэдээлэл солилцоог цахимжуулах төрийн үйл ажиллагааг оновчтой болгож холбогдох хууль, эрх зүйн орчныг боловсронгуй.

Г.Тэмүүлэн: Тэгье, Батцэцэг сайд.

Б.Батцэцэг: Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя.

Манай салбарын асуудлыг их ойлгож хөндөж байгаад маш их талархаж байна. Тэгээд харамсалтай нь энэ бас Засгийн газрын гишүүний хувиар энэ төсвийнхөө бодлогод захирагдахаас өөр аргагүй байгаа. Манай дипломатуудын цалингийн хувьд би бас хэлсэн. Түрүүн ер нь бид нар маш бага цалингаар цөөхөн хүн ажилладаг. Яваандаа бол хүний нөөцийн тогтвор суурьшилд бас нөлөөлөх ийм эрсдэлтэй одоо ч нөлөөлөөд эхэлж байгаа. Хилийн чанадад ажиллаж байгаа улсуудын ялангуяа өртөг өндөртэй Нью-Йорк, Женев, Хонконг, Сингапур зэрэг улсуудад байгаа авч байгаа цалин бол 2 мянга гаран доллар хаанаа ч хүрдэггүй гэр бүлээ тэтгэх битгий хэл энэ салбарт ажиллахгүй. Өөр энэ өндөр чадвартай 3, 4 хэлний мэдлэгтэй, маш өндөр, ур чадвартай дипломатуудаа бас нэлээд хувийн хэвшилд алдах ийм эрсдэлүүд гарч байгаа. Тэгээд цаашдаа бид нар яах вэ энэ ГХЯ бол төрийн тусгай алба гэж явдаг. Тэгсэн мөртөө яг цалингийнх нь ангилал нь төрийн тусгай байгууллагууд шиг.

Г.Тэмүүлэн: Нэмээд өгье. Минут нэмээд өгье.

Б.Батцэцэг: Тийм тэгээд цаашдаа бид нар энэ төрийн тусгай алба гэдэг ангилалдаа ороод бусад тусгай албадууд шиг ингэж сүлжээгээр цалинжих юм бол бусад яамдуудтай зэрэгцэхгүйгээр зүгээр зарим оронд бол дипломатууд гадаадад дотоодод ажиллахтай адилхан цалин авдаг. Тийм учраас гадаад явах гэж уралддаггүй. Гадаад явах 4 жилдээ л тэр хүний амьдрал санхүү жоохон бэхэждэг. Бусад энд байхдаа бол бусад яамдуудтай адилхан төрийн албан хаагчийнхаа сүлжээгээр ингээд цалинждаг. Тэгэхээр энийг бол цаашдаа төрийн тусгай алба гэдгээр нь ангилалд оруулж цалинг нь бас харгалзаж үзэх ёстой гэж үздэг.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Бямбацогт сайд.

С.Бямбацогт: 2025 оны төсөв дээр Батлан хамгаалах сайдын багц төсөв бол бас нэлээн буурч орж ирсэн байгаа. 821 тэрбум нийт зардал. Үүнээс урсгал зардлыг 746 тэрбум, хөрөнгө оруулалтыг 75 тэрбум гэж байгаа юм. Энэ төсөв мөнгө одоо бас ирэх жилийн үйл ажиллагаа явуулахад хүрэлцэх үү гэдэг дээрээ бол ер нь энэ хүрэлцэхгүй байгаа. Ер нь урьд урьд нь ч гэсэн батлан хамгаалах салбарт харьцангуй бас бага мөнгө тавьж үйл ажиллагаа зарцуулах асуудал дээр 2 дугаарт тавьж ирсэн юм байна лээ. Дэлхий нийтийн геополитик улс төр тиймээ нөхцөл байдал нэлээн амаргүй болж байгаа. Улс орон болгон дэлхийн бүх улс орнууд батлан хамгаалах салбарынхаа зардлыг нэмэгдүүлж байгаа.

Цэрэг зэвсэг техникээ шинэчилж сайжруулж байгаа. Бүгд л дэлхий нийтээрээ тийм байгаа. Энэ цаг үед бас манай төсөв бол бас манай холбогдох хуулиудаараа бол гол нь нийт төсвийн зарлагын 2 хувь.

Г.Тэмүүлэн: Бямбацогт сайд.

С.Бямбацогт: Холбогдох хуулиудаараа бол нийт төсвийн зардлын 2 хувьтай тэнцэх хэмжээний төсвийн зардал тавьж байх ёстой хэсэг байдаг мөртөө ер нь 0.6-0.7 орчим хувь л тавьдаг юм байна лээ. Дэлхийн одоо тэгвэл дээд тал нь 15 хувь, одоо АНУ Израил зэрэг улсууд 4 хувь, төсвийнх нь нийт зардал нь 4 хувийг батлан хамгаалах салбартаа зарцуулж байна. Доод тал нь үндсэндээ 2 хувь зарцуулж байгаа. Ингээд аваад үзэхээр ийм байгаад байгаа. Дотооддоо ч гэсэн нөхцөл байдал бас амаргүй байгаа. Маш олон цэргийн ангийн гал тогооны байр, цэргийн байр, цэргийн штабын байр гээд байрнууд нь бүгд их засвар хийх шаардлагатай болчихсон. 70, 80 жилийн насжилттай. Цэргийн ангийн удирдаж байгаа удирдагч захирагч нарын унах унаа байхгүй гахай явган нөгөө нохой нүцгэн гэж хэлдэг ийм байдалтай байгаад байгаа. Тэгээд энийг шийдэхэд л бас зайлшгүй хөрөнгө оруулалт хэрэгтэй. Бид нар бас цэргийг зөвхөн цэргийн эрдэмд суралцахаас гадна жолооны курс, гадаад хэл, англи хэл мөн бас мэдээллийн технологи компьютерын мэдлэгтэй болгох ийм ёстой шинээр сургалтын хөтөлбөр боловсруулж ирэх юм бас хэрэгжүүлж эхлэх гэж байгаа.

Г.Тэмүүлэн: Батсүмбэрэл гишүүн нэмж тодруулах уу?

Н.Батсүмбэрэл: Сангийн сайдаас орж ирэх үү? Би Сангийн сайдаас 2 асуулт байна.

Нэгдүгээрт төсөвт тодотгол хийх үү? Тодотгол хийх юм бол ямар бодлого барих юм. Дахиад хэмнэх юм уу? Үр ашигтай байх юм уу?

Хоёрдугаарт төсөв буцсан дээрээ Сангийн яам дүгнэлт хийж байгаа юм уу? Хариуцлага ярьж байгаа юм уу дотроо? Энд тодорхой хариулт авмаар байна.

Гуравдугаарт, тэр ТУЗ-ууд хороодын нэрийн жагсаалт нууц биш бол өгч болох уу?

Г.Тэмүүлэн: 3 номер. Бат-Эрдэнэ ТУЗ, хороодтой холбоотой асуулт дээр хариулъя.

Саяынх дээр би бас зүгээр нэмэлт мэдээлэл болгоод хэлэхэд яах вэ нэг талдаа тодотголоос сая өмнөх төсөв батлагдсан байсан. Төсвөөс хойш шинээр өргөн баригдаж байгаа төсөв бол хэмнэлт хийгдэж байгаа. Гэхдээ 4 сарын өмнө батлагдсан. 2024 оны тодотголоос хойшоо бол ер нь яамдуудын зардлыг бас бид нар нэмж өгсөн байгаа шүү. Та бүхэн бас мэд танилцуулга мэдээлэл дээрээс харж байгаа байх. Яг БХЯ-ны зардал 2024 оны тодотголоор буюу 4 сард 613 тэрбум байсныг бид нар 200 тэрбум төгрөгөөр нэмж өгсөн байгаа. Бүр өмнөх яг жилийн өмнө батлагдсан 2024 оныхоо төсөвтэйгөө харьцуулж үзэх юм бол өшөө өндөр дүн байгаа. Тэгэхээр бол бид нар ямар ч бай энэ гол гадаад харилцаа болоод батлан хамгаалахын салбар дээр бол Монголын төрөөс бол анхаарч үзэж байгаагийн бодит илэрхийлэл бол энэ байгаа. Цэвэр урсгал зардал дээрээс тодорхой хэмжиж болох зардлууд дээр хэмнэлт гарч байгаа болохоос биш бодлогын түвшиндээ бол дэмжлэгээ үзүүлээд явж байгаа гэдгийг бол бас анхаарч үзэх ёстой байх аа. Салбарын яамдууд.

Эрдэнэболд гишүүн асуулт асууя.

С.Эрдэнэболд: Намар нөгөө төсөв яригдаж байхад би аудит Сангийн яам 2-оос асуух гэж байгаа юм. Төсөв яригдаж байхад үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай төсөв нийцэж байгаа эсэх талаар хяналт тавих атал тухайн үедээ аудитын газрын тайлан дээр бол хянаж чадаагүй нийцэж байгаа эсэхийг хянаж чадаагүй ээ. Учир нь хэмжих нэгж тодорхойгүй байна гэж хэлж байсан. Тэгээд энэ асуудал дахиад ингэж орж ирж байгаа юу? Аудитын газраас асуугаад тэгээд дахиад тодруулж асууя.

Г.Тэмүүлэн: Аудит асуултад хариулъя нэг номер.

Ц.Наранчимэг: Гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Наранчимэг байна.

Энэ дахин өргөн барьсан төсөвт бол өмнө нь аудитын тайлан дээр яригдсан үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцсэн хэсгийг үнэлэх шалгуур үзүүлэлт тодорхойгүй хэвээр байна гэсэн энэ асуудал хэвээрээ байгаа. Өмнөх зөвлөмж хэрэгжээгүй байна гэсэн энэ дүгнэлт бол хэрэгжээгүй байгаа. Зүгээр агуулгаараа бол үндэсний аюулгүй байдлын үзэл баримттай нийцсэн. Гэхдээ нийцсэнийг үнэлэх журам шалгуур үзүүлэлтийг тодорхой болгох шаардлагатай байна. Хэвээрээ байгаа тайланд яг хэвээрээ тусгагдсан.

Г.Тэмүүлэн: Нэмж тодруулъя Эрдэнэболд гишүүн.

С.Эрдэнэболд: Тэгэхээр яг одоо энэ дээр 2 зүйл байгаад байгаа юм.

Нэгдүгээрт, ер нь энэ бид нар үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцэж байгаад хяналт хийхгүй болохлоор төсвийн төсөв дээр жишээлбэл эрэмбэ тодорхойгүй байгаад байгаа байхгүй юу. Зарим нь болохлоор юу гэдэг юм Хавдрын эмнэлэг байх ёстой гээд л зарим нь нөгөө талд нь юм тавиад орж ирж байгаа төсвүүдийг хооронд нь өрсөлдүүлэх, тухайн тохиолдолд улс төржилт хэрхэн явагдаж байгаа олон нийтэд хэрхэн тайлбарлаж байгаа дээрээс нь улс төрийн тухайн сэдэв авч явж байгаа хүмүүсийн хувийн чанараас болоод зарим төсөв унаад зарим төсөв нь нэмэгдээд ч юм уу ингээд яваад байгаа байхгүй юу. Тэгэхээр энд хувь хүний үзэмж субъектив хандлага гэхээсээ илүү улс төрчийн тэр зангараг наадах цаадах юмнаас илүүтэйгээр яг энэ үндэсний аюулгүй байдал хянах ёстой юу үндэсний аюулгүй байдал гэхлээр бид нар нэг тийм зөвхөн цэрэг цагдаа ч гэдэг юм уу тийм хүрээнд бас бодоод байж болохгүй ээ. Энэ жишээлбэл Монгол хүний амь нас, эрүүл мэнд алдагдаж байгаа буюу хүний үндсэн эрх зөрчигдөж байгаа асуудлыг бууруулахад чиглэж бид нар төсөв дээр бас хандах ёстой болчихоод байгаа юм, нэг.

Хоёрдугаарт.../минут дуусав/.

Г.Тэмүүлэн: Нэмээд нэг минут өгье.

С.Эрдэнэболд: Хоёрдугаарт сая Улсын Их Хурлаас 2024-2028 оны стратеги төлөвлөгөө гэж баталсан. Энэ төлөвлөгөөн дээр бол 5 бүлэг ороод эхний шалгуур үзүүлэлт нь бол хүн төвтэй байх гээд ингээд ороод явчхаж байгаа. Тэгэхээр одоо энэ дээр бол яг энэ урьд нь харанхуй байгаад байсан тэр хэмжих нэгж тодорхойгүй зүйл дээр хэмжих нэгжийн нэг үзүүлэлт болоод энэ орж ирж байгаа. Тэгэхээр Улсын Их Хурлаас гарч байгаа аливаа шийдвэрүүд нь дараах шаардлагуудыг хангасан байна гэдэг ийм функцтэй учраас та бүхэн хэрвээ боломжтой бол яг энэ 2024-2028

оны Улсын Их Хурлын стратегийн хүрээнд энэ хяналтыг нэг явуулмаар байгаад байгаа юм 1-д.

Хоёрдугаарт, яг тодорхойгүй байна гээд ингээд асуултын тэмдэг тавиад байхаас илүүтэйгээр хаанаас гарах юм тэр хэмжих нэгж шалгуур нь. ҮАБЗ-өөс гарах юм уу, эс үгүй бол Улсын Их Хурлаас гарах юм уу? Хаанаас гарах юм гэдэг зүйлээ бас бид нар энэ Байнгын хорооны хурал дээр ярьж байгаад нэг чиглэл зааж өгөхгүй бол бахь байдгаараа асуудал шийдэгдэхгүй байсаар байгаад байгаа. Энэний шалтгаант холбоогоо.

Г.Тэмүүлэн: Асуултад хариулъя. Нэг номер. Үндэсний аудитын газар.

Ц.Наранчимэг: Эрдэнэболд гишүүний асуултад хариулъя. Үндэсний аудитын газар Наранчимэг.

Монгол Улсын 2010 оны Их Хурлын 48 дугаар тогтоолоор Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 4.3.1-д Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын хэрэгжилтэд хяналт шинжилгээ, дүн шинжилгээ хийх аюулгүй байдлын нөхцөл байдалд үнэлгээ өгөх шалгуур үзүүлэлтийг ҮАБЗ боловсруулна гэж заасан байгаа юм.

Тэгэхээр ҮАБЗ энэ шалгуур үзүүлэлтийг боловсруулна.

Г.Тэмүүлэн: Нэмж хариулъя. Нэг номер.

Ц.Наранчимэг: Дутагдсан стратегийг боловсруулж шалгуур үзүүлэлтийг бид нар авч болно. Аудит хийхдээ аудитынхаа төлөвлөгөөнд суурь шалгуур үзүүлэлтээ авахаар оруулаад үзэж болно. Хойшид анхаарч ажиллая.

Г.Тэмүүлэн: Нэмэх үү? Нэг минут нэмж тодруулъя.

С.Эрдэнэболд: Тэгэхээр энэ 2 зүйл байгаад байгаа юм. Нэгд нь болохоор саяын тэр 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг Эдийн засаг, хөгжлийн сайдад бас би албан ёсоор хандсан. Энэ яаман дээрээ бас яг энийг шалгуур үзүүлэлт болгоод энэ төсөв дээрээ нэг филтер хийгээдхээч гээд. Тэр аудитын газраас энэ 2024-2028 онд хэрэгжиж байгаа стратегийг бас барьж авч байгаад энэ төсөв дээрээ нэг бүүр албан ёсоор энэ болж өгвөл энэ чуулганы хуралдаан эд нарт орохоос өмнө амжуулаад хийгээдхээч ээ. Тэгэх юм бол бид нар тэрэн дээр бас тодорхой үр дүн гарах гээд байна.

Хоёдугаарт тэр ҮАБЗ дээр хаанаас хүсэлт тавих юм. Манай Байнгын хорооноос байж болох юм уу, үгүй юу? Энэ тэр шалгуур үзүүлэлтийнхээ хэмжих нэгж ч гэдэг юм уу тэр зүйлээ бас тодорхой болгохыг бид нар шаардмаар байгаад байгаа юм. Тэгэхгүй болохлоор энэ нөгөө төсөв дээр эрэмбийн асуудал чинь олон улс төржилттэй завхраад манай төсөв бол их тийм хэцүү төсөв болоод байгаа юм аа. Энэ нэг удаагийн тохиолдол биш. Цааш цаашдаа энийг бас бид нар харах үүднээс энийг хэдүүлээ шийдье. Тэгэхээр энэ дээр бол аудитаас бас саналаа ирүүлээч албан ёсоор.

Г.Тэмүүлэн: Санал хэллээ гэж ойлголоо.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хуулийн төсөлтэй холбогдуулаад санал гаргаж, үг хэлэх гишүүд байгаа юу? Батсүмбэрэл гишүүнээр тасалъя. Батсүмбэрэл гишүүн.

Уучлаарай Тэмүүжин гишүүн байсан байна.

Х.Тэмүүжин: Төсвийн төсөлтэй холбогдуулаад зүгээр 2, 3 зүйл хэлмээр санагдсан юм. Эхнийх нь болохоор энэ Шадар сайдын багц буюу Онцгой байдлын байгууллагатай холбоотой төсвийн таналт байна. Сургалт семинар, биеийн тамирын тэмцээн зохион байгуулах гэх мэтчилэн энэ зардлыг 50 хувиар хассан гэнэ ээ. Ер нь онцгой байдлын байгууллагын үйл ажиллагааг харахаар дотоод сургалт яг мэргэжлийн энэ нөгөө зааварчилгаа тэгээд дотоод энэ нэг тэмцээн уралдаан энэ чинь өөрөө нэг тусдаа чиг үүрэгтэй байдаг онцгой байдалтай холбоотой гал түймэр гээд хүний амь настай холбоотой байдаг. Энэ чиглэлийнх нь дадлагажих үйл ажиллагааг 50 хувиар ингээд механикаар хасчих юм бол одоо байгаа нөхцөл нь, чадвар маш муу байгаа.

Дараагийн цаашдах нөхцөл нь бүүр муудаж магадгүй байгаад байгаа байхгүй юу. Та бүхэн харсан. Газ дэлбэрэхэд л газтай яаж харьцах тухай ямар ч мэдлэг байхгүй байна лээ. Газтай холбоотой тоног төхөөрөмж энэ газаас үүсэлтэй гал унтраахтай холбоотой ямар ч туршлага байхгүй байна лээ. Тэгэхээр энэ чиглэлийнх нь юмыг нөгөө жоохон анхаараарай гэж хэлэх гэж байгаа юм. Ер нь бол энэ онцгой байдлын байгууллагыг энэ төрийн цэргийн алба байгууллага болгож хувиргасан нь өөрөө хамгийн том алдаа байхгүй юу. Үр ашиггүй төсөв зардал маш их байгаа. Галтай холбоотой, үйл ажиллагаа явуулдагтай холбоотой энэ хувцас хэрэгслээ авч чадахгүй мөртөө бүгдээрээ нэг цэргийн хувцас өмсөөд яваад бүгд байгаа байхгүй юу. Хамаг мөнгө нь тэр нэг даргын өмнө жагсах, цэрэг болж тоглох энэ нэг хийрхэлд нь зарж байгаа юм.

Тэгэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо ч гэсэн санаачилга гаргаад ер нь аудитад би ийм чиглэл өгмөөр санагдаад байгаа юм.

Цаад дэвшилттэй иргэний эрхийг хамгаалдаг мэргэшсэн байгууллагууд улс орнууд чинь энэ тусгай байгууллага дотроо ямар хүн нь дүрэмт хувцас өмсөх юм өмсөхгүй юм. Юуны форм хэн хэрэглэх хэрэглэхгүйг нь бүүр нарийн заагаад өгчихсөн байгаа шүү дээ. Манайхан болохоор нярав байсан ч гэсэн л дүрэмт хувцас өмсөөд л тэнд захиргааны ажил хийсэн ч гэсэн тусгай хангамж авах гээд л цол зэрэг эдлэх гээд л. Ингээд төрд ачаа өгөөд төсвийг хэтийдсэн ийм зардал гаргаад байгаа байхгүй юу. Тэгээд энийг нь бид нар яаж хянах юм, цэгцлэх юм гэдгээ нэг яримаар байна. Цэргийн дүрэмт хувцас өмсөх шаардлагагүй, цол зэрэг хэрэглэх шаардлагагүй байгууллагуудаа одоо иргэний болгомоор байна. Тэгэхгүй төсвийн энэ мөнгө чинь маш их үрэлгэн буюу гарын салаагаар урсаж байгааг бид нар хармаар байна.

Сая ингээд л аудитын байгууллага гэхэд л 2 үг хэлээд байгаа байхгүй юу. Нэг нь төрийн аудит гээд л, нэг нь Үндэсний аудит гээд л. Одоо бид нар энийг хэтэрхий гоёчилсон байдлаар хуульчлахаа болих хэрэгтэй.

Монгол Улс Үндэсний аудитдаа энэ чиглэлээрээ хяналт тавьдаг байхад хангалттай болохоос биш төрийн гэдэг нэр зүүхээрээ бүүр том болчихдог юм байхгүй шүү дээ. Үндсэн хуулийн байгуулал дотор төрийн байгуулал гэдэг үг байгаа

болохоос биш энэ бүх юмыг төржүүлэх байдлаар томьёолох тийм утга угаасаа байхгүй. Гэх мэтчилэн нэр томьёогоо зөв зохион байгуулаагүйгээс болоод л ард нь гарч байгаа зардал мөнгийг харахаар маш үрэлгэн байгаа байхгүй юу. Энэ үрэлгэн байгаа тогтолцоогоо жоохон үр ашигтай болгох чиглэлээр хандвал яасан юм бэ гээд. Тэгээд энэ онцгой байдалтай холбоотой хэсэг дээр би дотор нь байгаа зүйл заалтуудыг нь нарийвчилж хараагүй байна. Цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх онцгой байдлын байгууллагууд дотор үр ашиггүй маш их зардлууд байгаа.

Нөгөө спорт, урлаг хариуцсан нэгжүүдээс авхуулаад л үр ашиггүй цол зэргээс авхуулаад тухайлбал бид нар ч гэсэн санаачилгаа гаргаад Улсын Их Хурлын гишүүд дээр цол зэргийн нэмэгдэл өгч болохгүй шүү дээ. Парламентын гишүүн сонгогдсон цол зэргийн нэмэгдэл байгаа академик түвшиндээ хэрэглэж болно. Тэгэхгүй бол одоо шүүх хүртэл юу ярьж байна гэхээр нэрлэсэн цалин нь бага. Цол зэрэг авахгүй бол прокурор.

Г.Тэмүүлэн: Тэгье 1 минут нэмээд өгье. Тэмүжин гишүүнд.

Х.Тэмүжин: Одоо шүүх дээр жишээ нь тийм нэрлэсэн цалин нь өндөр харагдаад байгаа. Тэгсэн мөртөө гар дээр авч байгаа цалин нь бага, прокурор цагдаа өөр бусад байгууллагууд дээр нэрлэсэн цалин нь бага боловч нөгөө цол зэргийн нэмэгдлээр маш өндөр цалин авчаж байгаа юм. Тэгээд одоо шүүхийнхэн бүүр ингээд энэ гажиг тогтолцоондоо бууж өгөөд шүүгч нар зэрэг авмаар байна гэж хэлж байгаа байхгүй юу. Цол зэрэгтэй болмоор байна гээд. Тэгээд яах юм шударга 1 дүгээр зэргийн шударга шүүгч, 2 дугаар зэргийн шударга шүүгч гээд ялгамжтай болох юм уу? Прокурор бас яг ийм байгаа. Дотроо зэрэг цол хэрэглээд цалин мөнгө нь ялгамжтай. Тэгэхээр ингээд одоо ингээд зэрэг цол хэрэглэж болдоггүй албуудаа цэгцэлж аваад зэрэг цолтой байдаг албуудаа цэгцэлж аваад ялгааг нь гаргаж авахгүй бол энэ нэг цалин хангамж чинь төсөв дээр нэмэгдлүүд нь бүүр үндсэн цалингаасаа бүүр даваад явчих хэмжээний галзуурч эхэллээ.

Тэгэхээр энэ хэрэв үнэхээр төсвийг үр ашигтай болгоё гэж бодож байвал доторх задаргаанууд дээр нэлээн сайн ажилламаар байна аа. Тэгэхгүй механик таналт хэрэггүй.

Г.Тэмүүлэн: Манай Сангийн яамныхан энэ асуудлыг бас анхаарч үзээрэй. Төсвийн төлөвлөлт дээр урсгал зардал дээр. Батсүмбэрэл гишүүн санал хэлье.

Н.Батсүмбэрэл: Минийх Тэмүжин гишүүнийхтэй ер нь ойролцоо байна. Залгуулаад ярьчихъя аа. Ер нь бол энэ Сангийн яам бол энэ хэт их хэтрүүлэн танадаг хэтрүүлэн хэмнэдэг байдалдаа бас нэг жоохон анхаармаар байгаа юм. Ер нь эцсийн дүн дээрээ төсвийн тодотгол нь буцчихсан шахуу, төсөв нь буцчихсан ийм анхны тохиолдол гарсан гээд байгаа. Энэ мэргэжлийн яам өөрөө дотроо ажлаа анхаарах ёстой л асуудал болж таарч байгаа.

Ялангуяа манай гадаад аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хороонд харьяалагдаж байгаа энэ БХЯ онцгой байдлын байгууллага, ГХЯ гээд ингэхдээ энэ тусгай чиг үүргийн улс орны аюулгүй байдалтай холбоотой иргэний амь нас эд хөрөнгийг авран хамгаалахтай холбоотой гадаад улс оронд Монгол Улсыг төлөөлдөг нэр хүндийг хамгаалдаг, гадаад харилцааны бодлогоор Монголын эдийн засгийг бэхжүүлдэг энэ ажлыг хийдэг салбаруудын төсвийг механикаар танадаг байдлыг зогсоох ёстой, Үүнийг бодолцох ёстой. Үүн дээр Аюулгүй байдал, гадаад

бодлогын байнгын хороо тусгайлан дүгнэлт зөвлөмж гаргаж болмоор байгаа юм. Байнгын хорооны даргад хэлэхэд дээрээс нь сая ярьж байгаа тэр ГХЯ-ны ажилтнуудын тусгай албан хаагчийн статусын асуудлыг Байнгын хороо тусгайлан авч үзэж энэ жин дээр дүгнэлт зөвлөмж гаргах нь зөв өө. Бодит амьдрал дээр тэр хүмүүс ямар зардлаар яаж хүнд нөхцөлд ажиллаж бусад улс орнуудтай дипломат аргаар өрсөлдөн ажиллаж байна гэдэг бас амаргүй.

Тэгэхээр энийг бид тусгайлан авч үзэж тэр тусгай албан хаагчийн асуудлыг нь бодитойгоор ойрын хугацаанд шийдэж өгөх нь зөв байх. Энэ төсвийн хэмнэлтийн хуулийг өөрчилье, илүү сайжруулъя аа. Энэ хууль үүргээ гүйцэтгэсэн зарим талаас улам сайн болгох шаардлага байна. Зарим талаас орон нутагт бас хүндрэл чирэгдэл болоод байгаа асуудлуудыг нь хасах өөрчлөх зайлшгүй шаардлага байна гэж Их Хурлын зарим гишүүд гарын үсэг зурж энэ саналыг тавьж байгаа юм. Харамсалтай нь зарим нөхдүүд энийг мушгин гуйвуулж гүтгэж байгаа сураг дуулдана лээ. Үүнийгээ болиорой. Та нарын ажлыг бид урагш нь явуулахын төлөө энд нэг талд дуугараад байдаг. Тэгээд гишүүд үг хэлэхээр сүүлдээ загнадаг болох шинжтэй байна лээ. Тэр өнгөрсөн 5 дахь өдрийн чуулган дээр Гантөмөр гээд нөхөр бараг үг хэлсэн гишүүн болгоныг загнаж байна лээ. Тэр яамны нөхдүүд энэ дээр сайддаа хэлнэ биз.

Ер нь энэ саяын яриад байгаа асуудлуудаар ер нь бид нар нэг цаг үеийн асуудлаар хуралддаг болчихоод байна. Байнгын хороо нэг хурлын даргаас өгсөн чиглэлийн дагуу эс үгүй бол нэг Төсвийн хуулийн дагуу эс үгүй бол ийм байдлаар Байнгын хорооны дарга энэ асуудлыг анхаарч авч үзээд энэ манай харьяанд байгаа энэ батлан хамгаалах салбар, онцгой байдлын салбар, гадаад харилцааны салбарын асуудлыг нь тусгайлан нэг нээлттэй юм уу, хаалттай байдлаар авч үзэх нь зөв байна. Энэ үндэсний аюулгүй байдлын асуудал төсөв төслийг эрэмбэлэх асуудлыг Эрдэнэболд гишүүн хэд хэдэн удаагийн хурал дээр ярьж байгаа юм. Энийг бид бас шаардлагатай хаалттай байдлаар ярих хэрэгтэй.

Заавал энэ чинь цэрэг стратегийн зарчмаар биш уламжлалт бус аргаар бас улс орны аюулгүй байдлыг хамгаалдаг зөөлөн бодлогоор явуулдаг ийм асуудлууд байж байна. Цахим аюулгүй байдлын асуудал байж байна. Бид энэ дээр бас анхаарах ёстой асуудал. Бид нар аюулгүй байдлын чиглэлийн асуудал хариуцдаг Байнгын хороо байж байна. Энэ гадаад харилцааныхаа асуудлыг ярих ёстой ийм асуудлуудыг Байнгын хороо бас нэг тийм товчилж яримаар байгаа.

Тэгээд энэ бас чуулган дээр бас зарим зүйлийг ярья. Тэгээд бас ингээд гишүүд үг хэлэхээр нь сайд загнадаг болчихсон байна лээ. Тэр Гантөмөр нөхрөөс эхлээд. Гантөмөрт загнуулах гэж гишүүн болж энд суугаагүй шүү тэр нөхөрт хэлэхэд.

Г.Тэмүүлэн: Гишүүд үг хэлж дууслаа. Саяын Батсүмбэрэл гишүүний хэлсэн асуудалтай холбогдуулаад энэ он дуустал бол манай Байнгын хороон дээр бас хаалттай хэд хэдэн асуултууд хүлээгдэж байгаа. Төсвийн хэлэлцүүлгүүд дууссаны дараагаар бол эдгээр асуудлууд хэлэлцэгдэх товтой байгаа гэдгийг бол бас Байнгын хорооны гишүүддээ мэдээлээд хэлчихье ээ. Ингээд хуулийн төсөлтэй холбогдуулж гишүүд үг хэлж дууслаа.

Санал хураалт явуулъя. Санал гаргаагүй байгаа учраас явуулах санал байхгүй байна.

Төсвийн төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн байнгын хороонд танилцуулах учиртай байгаа.

Манай байнгын хороонд Төсвийн байнгын хорооноос гишүүн байгаа билүү? Тийм байх. Батцэцэг сайд болохгүй. Эрдэнэболд гишүүн байгаа билүү? Эрдэнэболд гишүүнээр томилъё.

Ингээд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

12.05 цагт

Дараагийн асуудалдаа оръё.

2 дахь асуудал. [Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцүүлгийг явуулж эхэлье.](#)

Оролцож байгаа албан тушаалтнууд хэвээрээ байгаа.

Сангийн яам үлдэх ёстой биз дээ? Сангийн яам үлдэх ёстой. Сангийн яамны албан тушаалтнууд. Та танилцуулчих уу? Сангийн сайд бас ирж танилцуулга хийх ёстой байгаад байгаа. Одоохон хүлээж байгаарай. Тэгвэл Бямбацогт сайд танилцуулаадах. Өнөөдөр чинь бас 12 сарын 9-ний өдөр манай Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны гишүүн Батцэцэг сайдын маань бас төрсөн өдөр байгаа. Тэгээд Байнгын хорооныхоо гишүүдийнхээ өмнөөс Батцэцэг сайддаа бас эрүүл энх, хамгийн сайн сайхан бүхнийг бас хүсэн ерөөж байна.

Тэгээд ажлын өндөр амжилтыг хүсье.

Бямбацогт сайд хуулийн хууль тогтоолын төслүүдийн талаарх танилцуулгыг Засгийн газраас танилцуулах байгаа. Бямбацогт сайд.

Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн талаарх хууль санаачлагчийн танилцуулгыг Бямбацогт сайд танилцуулна.

С.Бямбацогт: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт 11 хуулийн төсөл, 4 Их Хурлын тогтоолын төслийг 2024 оны 12 дугаар сарын 4-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ. Хууль тогтоомжийн талаар товч дурдвал 1 дүгээрт нь төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд олон нийтийн болон хараат бус хөндлөнгийн хяналтыг өргөжүүлж, сахилга бат, хариуцлагыг сайжруулж, үр ашиг, бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Засгийн газрын газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл,

Хоёрдугаарт нь төсвийн урсгал зардал бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдахтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, хууль тогтоомжийн төслүүд батлагдсанаар бүсүүдийг төрөлжүүлэн хөгжүүлэх татварын ялгаатай бодлогыг 2025 оноос эхлэн хэрэгжүүлж бүс орон нутгийн төсвийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх бие даан хөрөнгө оруулалт татах эдийн засгийн бодлогоор өрсөлдөх урсгал зардлыг бууруулах боломжийг бүрдүүлнэ ээ.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоомжийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиараа Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр бол хэлэлцэнэ гэж бол заасан байгаа.

Ингээд зүйл бүрээр нь бол хэлэлцээд явъя.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулаад санал гаргаагүй гишүүдээс.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу? Алга байна байна.

2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асууя. Хосбаяр гишүүн асуулт асууна. Микрофон өгье.

Г.Хосбаяр: Үгүй тэгээд хэнээс нь асуух юм болдоо. Энэ нөгөө нэг хөдөө орон нутагт чинь ажил хийхэд нөгөө сумын удирдлагууд, дунд шатын дарга нар их хүнд байна гэж яриад байна л даа. Төсөв мөнгө байхгүй, унах унаа ч байхгүй гээд.

Тэгэхээр энэ Төсвийн хэмнэлтийн тухай хуулиа энүүгээр өөрчлөөд буцаад хэвд нь оруулах гээд байна уу эсвэл бүүр сунгах гээд байна уу? Тэгэхээр энэ дээр хариулах албан тушаалтан байхгүй юм шиг байна тэ? Сангийн яам байхгүй.

Г.Тэмүүлэн: Тэлмүүн хариулчих. Тэгээд чуулган дээр бас та хэд маань нэмэлт тайлбар хариулт Хосбаяр гишүүнд өгөөрэй. Нэг номер.

Б.Тэлмүүн: Сангийн яам Тэлмүүн гишүүний асуултад хариулъя. Төсөв дагаж Төрийн хэмнэлтийн хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл өргөн баригдсан. Төрийн хэмнэлтийн хууль бол 2022 оны төсвийн тухай хуулийн тодотголтой хамт өргөн баригдаад хүчин төгөлдөр болсон энэ хууль бол дуусах хугацаа гэж байхгүй. Ингээд байнгын үйлчлэх шинж чанартай ийм хууль байгаа. Өргөн барьсан төслийн

хүрээнд бол бид нар хуулийн хэрэгжих хугацаатай холбоотой ямар нэгэн өөрчлөлт байхгүй цаашдаа үргэлжлээд явна. Энэ дээр бид нэмэлт хэд хэдэн зардлуудыг хориглохоор ингэж оруулсан байгаа. Тэгээд энэ хууль бол батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөгдөх ийм зохицуулалттай байгаа.

Г.Тэмүүлэн: Хосбаяр гишүүн нэмж тодруулья.

Г.Хосбаяр: Одоо энэ өөрчлөлтөөр дуусах хугацааг нь наашлуулах ч юм уу тодорхой хугацаа тавих юм байхгүй юм байна шүү дээ тиймээ. Тэгэхээр чинь энэ улам их хэмнээд нөгөө хөдөө орон нутагт улам л асуудал үүсээд орон тоо нэмэгдээд, хүн ам өсөөд ингээд явж байхад нөгөө зардал нь улам хасагдаад ингээд яваад байхаар дунд шатандаа, анхан шатандаа ажил улам л төвөгтэй л болоод байна л даа. Тэгээд бас энэ өвөлжилт хүндэрдэг гээд л олон асуудлууд байгаа. Тэгэхээр энэ хэмнэлтийн тухай хуулиа ер нь тодорхой хугацаа зааж өгөөд хугацааг нь наашлуулж барих ийм боломж байхгүй юм уу. Энэ ер нь анхнаасаа ингэж хугацаагүй гэдэг нь ямар учиртай ингэж баталсан юм бол.

Г.Тэмүүлэн: Хосбаяр гишүүний асуултад хариулья. Тэлмүүн.

Б.Тэлмүүн: Сангийн яам нэмж хариулья. Хуулийн хэрэгжих хугацаатай холбоотой өөрчлөлт байхгүй. Энэ дээр бол бид төсвийг алдагдалгүй батлахтай холбоотойгоор бол бүх шатын төсвийн захирагч төсвийн байгууллагууд дээр тодорхой хэмжээний хэмнэлтүүд гарч явж байгаа.

Тэгэхээр Төрийн хэмнэлтийн хуульд нэмж байгаа энэ зардлуудтай холбоотой бол цаанаа дандаа зардлын хэмнэлтүүд яригдаж байгаа. Энэ хуулийг хүчингүй болгох байдаг юм уу, зарим зүйл заалтыг өөрчлөх, хэрэгжих хугацааг өөрчлөх асуудал бол тусдаа. Хуулийн төслийн хүрээнд яригдах асуудал байгаа. Яг одоогоор бол Засгийн газрын түвшинд Төрийн хэмнэлтийн хуулийг хүчингүй болгох хугацааг нь наашлуулахтай холбоотой яригдсан зүйл байхгүй байгаа.

Г.Тэмүүлэн: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж дууслаа.

“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлд хамт өргөн мэдүүлсэн Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

2025 оны төсвийн тухай хуулийн төсөлд хамт өргөн мэдүүлсэн” Засгийн газрын чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

“Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье.

Тус тогтоолын төсөлтэй холбогдуулж, асуулт асуух гишүүд байна уу. Алга байна. Ингээд тус тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Төсвийн тухай хуульд хамт өргөн мэдүүлсэн Төрийн хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, “Засгийн газарт чиглэл өгөх тухай”, “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэболд Төсвийн байнгын хороонд танилцуулна аа.

Хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Өнөөдрийн хэлэлцэх асуудал дууссан байна. Ингээд хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Идэвхтэй оролцсон ажлын хэсэг болоод гишүүддээ баярлалаа.

11.53 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА